



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 1/03

Улаанбаатар хот


Сургалтанд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны “хаягдал утааны хийн хэмжилтийн лаборатор”-ийн ажиллах нөхцөл, шаардлагыг хангах зорилгоор дэд дарга Х.Галымбек, орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн М.Отгонбаяр нарыг Стандартчилал, хэмжил зүйн газраас зохион байгуулж буй “Лаборатори итгэмжлэлийн сургалт”-д оролцуулсугай.

2. Сургалтын зардал болох 120 000 /нэг зуун хорин мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.БАТСАЙХАН